



Төрийн өмчийн хорооны 1997 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 772 дугаар тогтоолын хавсралт

Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч томилон ажиллуулах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмын зорилго нь Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгчийг /цаашид итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх/ томилон ажиллуулж, хувьчлагдах эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан хамгаалж, уул эд хөрөнгийг шинэ өмчлөгчид хүлээлгэж өгөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон ажиллуулах, өөрчлөх асуудлыг Өмч хувьчлалын газрын даргын санал болгосноор Хорооны дарга шийдвэрлэнэ.

3. Улаанбаатар хотоос алслагдсан байршилтай буюу ихээхэн хэмжээний эд хөрөнгөтэй хувьчлагдах аж ахуйн нэгжүүдийн хувьд дараах 2 чиглэлээр ажил, үүрэг хариуцан гүйцэтгэх итгэмжлэгдсэн төлөөлөгчийг төвийн болон орон нутгийн холбогдох ажилтнуудаас томилон ажиллуулна.

а/ Тухайн аж ахуйн нэгжийг хувьчлах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх үүрэгтэйгээр төвөөс ажиллах итгэмжлэгдсэн төлөөлөгч

б/ Хувьчлагдах аж ахуйн нэгжийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан хамгаалж, хөрөнгийн хөдөлгөөнд хяналт тавих үүрэгтэйгээр орон нутгаас томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч

4. Орон нутагт ажиллах итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр тухайн , нийслэлийн төрийн өмчийн төлөөлөгч, хувьчлагдах улсын үйлдвэрийн газрын дарга болон нутгийн захиргааны байгууллагаас итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллуулахыг санал болгосон бусад ажилтныг томилон ажиллуулж болно.

5. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хувьчлагдах аж ахуйн нэгж болон төрийн мэдлийн эд хөрөнгө, хувьцаа, ногдол хувийг хувьчлахаар шийдвэрлэгдсэн аж ахуйн нэгж,

байгууллагын /цаашид хувьчлагдах байгууллага гэх/ хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

6. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын болон орон нутгийн өмчийн тухай", "Нөхөрлөл компанийн тухай хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгон хуулийг дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, төрийн эрх ашиг сонирхлыг нэн тэргүүнд хүндэтгэн хамгаалах зарчим баримталж ажиллана.

7. Хувьчлагдах төрийн өмчийн эд хөрөнгийн тоо хэмжээ, үнэлгээг үнэн зөв тодорхойлоогүй болон өөрийн буруутай үйл ажиллагаанаас үүсэх хариуцлагыг итгэмжлэгдсэн төлөөлөгч хариуцна.

8. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн шийдвэрийг дагаж мөрдсөнтэй холбогдуулан гарах хариуцлагыг Хорооны Өмч хувьчлалын газар хариуцна.

9. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн томилогдон ажиллах хугацаанд хувьчлагдах байгууллагын албан тушаалтан түүний шийдвэрийг эс биелүүлсэн, санаатайгаар зөрчсөн бол түүнд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулна.

10. Хувьчлагдах байгууллагын эрх бүхий албан тушаалтан худал мэдээлэл өгсөн, мэдээ, судалгаа тайлан тэнцлийг санаатайгаар буруу гаргасан буюу хугацаа хожимдуулсан, мэдээллийг нуун дарагдуулсан бол түүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулна.

#### Хоёр. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үүрэг

11. Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг /цаашид үйлдвэрийн газар гэх/ хариуцан ажиллахаар томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дараах үүрэгтэй.

а/ итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон шийдвэр гарснаас эхлээд шинэ өмчлөгчид эд хөрөнгийг хүлээлгэн өгч дуусталх хугацаанд хувьчлагдах эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан хамгаалах,

б/ үйлдвэрийн газрыг хувьчлахын өмнө өөрчлөн байгуулах шаардлагатай гэж үзвэл санал боловсруулж Хороонд оруулж шийдвэрлүүлэх,

в/ хувьчлагдах аж ахуйн нэгж, эд хөрөнгөд тооллого хийлгэж, түүний дүнг шалгаж, үнэн зөвийг хариуцах, хувьчлалд эд хөрөнгийг орхигдуулалгүйгээр бүрэн хамааруулах,

г/ хувьчлагдах үйлдвэрийн газрынхаа эд хөрөнгийн үнэлгээг хянаж, дүрмийн сангийн хэмжээг үнэн зөв тодорхойлж, гаргах хувьцааны /хувь хөрөнгийн/ тоо, хэмжээг тогтоож батлуулах,

д/ хариуцсан үйлдвэрийн газрынхаа хувьчлалын арга хэлбэрийг өөрчлөх шаардлагатай гэж үзвэл энэ талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх,

е/ хувьчлагдах үйлдвэрийн газрынхаа хувьцаа, ногдол хувийг битүүмжилсэн болон нийтийн дуудлага худалдаагаар худалдах доод тогтоож батлуулах.

ё/ хувьчлагдах үйлдвэрийн газар, түүний эд хөрөнгийн талаар төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд сурталчлах зарлал, мэдээлэл, сурталчилгааны материалыг бэлтгэж өгөх, хувьчлалын талаар хариуцсан үйлдвэрийн газрынхаа ажиллагсдад яриа танилцуулга хийх, хувьчлагдах объектын талаар нийтэд зарлаж мэдээлэх, зар мэдээний үнэн зөв байдлыг хариуцан ажиллаж зохион байгуулах,

ж/ дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын дунд зарлах уралдаант шалгаруулалтаар /төсөл сонгон шалгаруулах/ хувьчлагдах байгууллагын төсөлд тавигдах нөхцөл, шаардлагыг боловсруулах, зарлах ажлыг зохион байгуулах,

з/ төсөл шалгаруулах шинжээчдийн талаар санал бэлтгэж Өмч хувьчлалын газарт оруулах,

и/ хариуцсан үйлдвэрийн газар, түүний эд хөрөнгийн хувьчлалтай холбогдсон тогтоол, шийдвэрийн төсөл, танилцуулга бэлтгэх,

к/ хариуцсан үйлдвэрийн газартаа Төрийн өмчийн хорооны 1997 оны 562 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон төрийн өмч оролцсон аж ахуйн нэгжийг хувьчлалд бэлтгэх, хувьчлагдсан аж ахуйн нэгжийг хүлээлгэж өгөх журам"-ын 3-р зүйлд заасан хувьчлалын бэлтгэл ажлын хүрээнд гүйцэтгэх ажлуудыг хийлгүүлэх

л/ хариуцсан үйлдвэрийн газартаа ажиллагчдын цалин хөлс олгохоос бусад мөнгөн гүйлгээ болон эд хөрөнгийн хөдөлгөөнийг зөвхөн өөрийнхөө бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хийлгэж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгжийн санхүүгийн болон мөнгөн гүйлгээний баримт бичигт гуравдагч гарын үсэг зурж байх.

м/ шинэ өмчлөгчтэй байгуулах "Худалдах, худалдан авах гэрээ"-г байгуулах ажлыг зохион байгуулах, биелэлтийг дүгнэж тайлагнах,

н/ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж хувьчилж авсан үйлдвэрийн газрынхаа хувьцаа, ногдол хувийн үнийг хугацаанд нь төлсөн этгээдэд өмчлөх эрх олгох тухай асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх,

о/ өмчлөх эрх олгосон тухай хорооны шийдвэрээр үйлдвэрийн газар, түүний эд хөрөнгийг шинэ өмчлөгчид хүлээлгэн өгөх, энэ тухай акт үйлдэх,

ө/ хувьчлагдсан эд хөрөнгийг хүлээлгэн өгөхөд гарсан эд хөрөнгийн илүүдэл, дутагдлын асуудлыг Хороонд тавьж шийдвэрлүүлэх,

п/ хувьчлалын тайланг "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн хорооноос баталсан тайлан бичих зааврын дагуу үйлдэж, Өмч хувьчлалын

газарт танилцуулж, хянуулаад Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах,

р/ Хорооны хуралдаанаар хэлэлцэж баталсан шийдвэр, тайлан, холбогдох бусад баримт бичгийг зохих журмын дагуу архивт шилжүүлэх,

т/ хариуцсан үйлдвэрийн газрынхаа хувьчлал болон өөрийн ажиллагаатай холбогдон гарах зардлын төсвийг хийж Өмч хувьчлалын газрын даргаар батлуулах.

12. Төрийн өмч оролцсон аж ахуйн нэгжийг хариуцан ажиллахаар томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч нь энэ журмын 11 дүгээр зүйлийн "б", "г"-д заагдсанаас бусад үүргийг хариуцсан аж ахуйн нэгжийнхээ хувьчлалтай холбогдуулан гүйцэтгэх үүрэгтэй.

13. Эд хөрөнгийн хувьчлалыг хариуцан ажиллахаар томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дараах үүрэгтэй.

а/ хариуцсан эд хөрөнгийнхөө хувьчлалтай холбогдуулж энэ журмын 11 дүгээр зүйлийн "а", "д", "ж-к", "н-т"-д заасан үүргийг гүйцэтгэх,

б/ хувьчлагдах эд хөрөнгийнхөө тоо, хэмжээ, бүрэлдэхүүн хэсэг, талбайн хэмжээ, зураглал, схемийг тодорхойлж, дуудлага худалдааны доод үнийг тодорхойлж, батлуулах,

в/ хариуцсан эд хөрөнгийнхөө бүтэц бүрэлдэхүүн, хөдөлгөөнд хяналт тавьж, түүнд өөрчлөлт оруулах асуудлыг зөвхөн өөрийн бичгээр өгсөн зөвшөөрлөөр гүйцэтгүүлэх.

14. Хувьчлагдах үйлдвэрийн газрын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан хамгаалж, түүний хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахаар томилогдсон орон нутгаас ажиллах итгэмжлэгдсэн төлөөлөгч дараах үүрэгтэй.

а/ хариуцан ажиллах үйлдвэрийн газартаа энэ журмын 11 дүгээр зүйлийн "а", "в", "к", "л", "м", "ө", "п", "т"-д заасан үүргийг гүйцэтгэх,

б/ тухайн аж ахуйн нэгжийг хувьчлах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх үүрэгтэйгээр төвөөс ажиллах итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хамтран энэ журмын 11 дүгээр зүйлийн бусад үүргийг гүйцэтгэх.

Гурав. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүлээх хариуцлага.

15. Итгэмжлэгдсэн төлөөлөгч дор дурдсан хариуцлага хүлээнэ.

а/ Энэхүү журмын 11 дугаар зүйлд заасан үүргийг бүрэн гүйцэд биелүүлээгүй, хариуцсан ажлаа дутуу биелүүлснээс үүсэх хохирлыг нөхөн төлүүлэх,

б/ Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажилласан хугацаанд хөрөнгийн хөдөлгөөн гарсан бол түүнээс үүдэн гарах хариуцлагыг итгэмжлэгдсэн хүлээнэ.

Дөрөв. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх

16. Итгэмжлэгдсэн төлөөлөгч дараах эрхтэй.

а/ холбогдох байгууллагуудаас хувьчлалын ажилд шаардагдах баримт материалыг гаргуулж авах,

б/ хувьчлагдах газрын үйл ажиллагаа, тайлан тэнцэл, чадварын талаар судалгаа шинжилгээ, дүгнэлт гаргуулж авах,

в/ шаардлагатай гэж үзвэл хувьчлагдах газрын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн байгууллагаар баримтын шалгалт хийлгэх,

г/ томилогдон ажиллаж байгаа аж ахуйн нэгжийнхээ ажиллагсдын цалин хөлснөөс бусад мөнгөн гүйлгээ, санхүүгийн баримтад гуравдагч гарын үсэг зурах,

д/ хувьчлагдах аж ахуйн нэгжийнхээ ажиллагсдын цалин хөлс тавьж олгохоос бусад эд хөрөнгөд өөрийн зөвшөөрөлгүйгээр хөдөлгөөн хийхийг хориглох,

е/ хувьчлагдах эд хөрөнгийн тоо хэмжээг үнэн зөв тогтоохын тулд шаардлагатай гэж үзсэн эд хөрөнгөд ахин тооллого, хэмжин шалгалт хийлгэх

ж/ хувьчлагдах эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хувьчлалаас гадуур бусдад худалдсан, шилжүүлсэн болон алдаж үрэгдүүлсэн байвал холбогдох буруутай этгээдэд хариуцлага оногдуулах, хохирлыг тооцож нөхөн төлүүлэх асуудлыг боловсруулж хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх,

з/ өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай бичиг хэргийн болон дүрс бичлэгийн техник хэрэгслэл, ажлын байр, унаа, холбоо, томилолтын зардлыг батлагдсан төсөвт багтаан зарцуулах

и/ хувьчлалтай холбогдсон хууль тогтоомж, дүрэм заавар бусад гарын авлага, арга зүйн материалууд болон нэгдсэн журмаар хэвлэгдсэн маягт, гэрээ, бусад зүйлсийг ажлын хэрэгцээнд авах.

Тав. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгох урамшуулал

17. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хариуцан ажилласан аж ахуйн нэгж, эд хөрөнгийн хувьчлалаас улсад орох орлогоос Төрийн өмчийн хорооны 1997 оны 110 дугаар тогтоолын дагуу байгуулсан урамшууллын сангийн эх үүсвэрт багтааж түүний ажлын үр дүнг харгалзан урамшуулал олгоно.

18. Хувьчлагдсан аж ахуйн нэгж, эд хөрөнгийн тайланг Хорооны хурлаар хэлэлцэж баталсны дараа итгэмжлэгдсэн төлөөлөгчид олгох шагналын хэмжээг холбогдох зааврын дагуу Өмч хувьчлалын газраас тодорхойлж, улирал бүрийн эцэст Хорооны даргын тушаалаар батлуулна. Урамшууллыг тооцохдоо дараах шалгуурыг харгалзана.

а/ хувьчлалын материалын бүрдүүлэлт, Хорооны хурлаар хэлэлцүүлсэн байдал

б/ Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилогдсоноос шинэ эзэмшигчид хүлээлгэн өгөх хүртэл хугацааны хөрөнгийн бүрэн бүтэн байдал, өр авлагын өсөлт, бууралт, барагдуулалт,

в/ Хувьчлах зар мэдээний гаргалт,

г/ Худалдах худалдан авах тухай гэрээний биелэлт,

д/ Дуудлагын худалдааг зохион байгуулсан дүн,

е/ Өмчлөгчийн эрх олголт, хугацааны мөрдөлт

ё/ Хувьчлалын тайлан, архивын материалын бүрдүүлэлт.

ж/ Хөдөө орон нутагт томилолтоор ажилласан бол томилолтын зардлын тооцоо, бичиг баримтын бүрдүүлэлт.

19. Улаанбаатар хотоос алслагдсан байршилтай буюу ихээхэн хэмжээний эд хөрөнгөтэй аж'ахуйн нэгжид энэ журмын 3 дугаар зүйлд заасны дагуу төвөөс болон орон нутгаас ажилласан итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд олгох урамшууллын хэмжээг тэдгээрийн хариуцсан ажил үүргийн биелэлтийг харгалзан, батлагдсан эх үүсвэрт багтаан олгоно.

#### Тав. Хувьчлагдах аж ахуйн нэгжийн үүрэг

20. Засгийн газрын болон Төрийн өмчийн хорооны тогтоолоор хувьчлагдахаар шийдвэрлэгдэж, итгэмжлэгдсэн төлөөлөгч томилогдсон хуулийн этгээдийн үүрэг

а/ хувьчлагдах эд хөрөнгөд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр ямар нэг хөдөлгөөн хийхгүй байх,

б/ хувьчлагдах эд хөрөнгийн тухай тогтоосон зааврын дагуу асуудал боловсруулж Өмч хувьчлалын газарт хүргүүлэх

в/ итгэмжлэгдсэн төлөөлөгчийн шаардсан материалыг цаг хугацаанд нь гаргаж өгөх,

г/ хувьчлах арга хэлбэрийг өөрчлөх шаардлагатай гэж үзвэл энэ талаарх саналаа хувьчлалын төсөлд тодорхой тусгасан байх,

д/ итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлж, ажлын өрөө, бичиг хэрэгслэлийн болон холбооны техник хэрэгслэл, унаагаар хангах /Төрийн өмчийн хорооны Өмч хувьчлалын газрын даргын баталсан төсвийн дагуу өөрийн үйлдвэр, аж ахуйн газар, байгууллагаас хувьчлалтай холбогдож гарах зардлыг гаргах/

е/ итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын дор Төрийн өмчийн хорооны 1997 оны 562 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон төрийн өмч оролцсон аж ахуйн нэгжийг хувьчлалд бэлтгэх, хувьчлагдсан аж ахуйн нэгжийг хүлээлгэн өгөх журам"-ын 3, 9, 11 дүгээр зүйлүүдэд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхээс

гадна шинэ өмчлөгчид дээрх журмын 13 дугаар зүйлд заасан бичиг баримт бусад зүйлсийг хүлээлгэн өгөхөөр бэлэн болгох.